



VII-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 11




## Орон сууцны үнэ өмнөх улирлаас 1.4 хувиар өссөн байна

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2021 оны 3 дугаар улиралд 2010 оны эцсээс 81.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар, өмнөх улирлаас 1.4 хувиар тус тус өссөн байна.

Орон сууцны үнэ 2021 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс Баянгол дүүрэгт 2.5 хувь, Хан-Уул дүүрэгт 2.2 хувь, Чингэлтэй болон Сүхбаатар дүүрэгт 1.8 хувь, Баянзүрх дүүрэгт 0.7 хувиар тус тус өссөн байна. Харин Сонгинохайрхан дүүрэгт 1.1 хувиар буурсан байна. Орон сууцны үнийн индекс өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өсөхөд 2001 оноос хойш ашиглалтад орсон шинэ орон сууцны үнэ Баянгол дүүрэгт 6.1 хувь, Хан-Уул дүүрэгт 5.3 хувь, Чингэлтэй дүүрэгт 4.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


ЗУРАГ 1: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Орон сууцны үнэ 2021 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас Баянгол дүүрэгт 1.9 хувь, Хан-Уул дүүрэгт 1.6 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 1.4 хувь, Баянзүрх дүүрэгт 1.3 хувь, Чингэлтэй дүүрэгт 1.2 хувь, Сүхбаатар дүүрэгт 0.9 хувиар тус тус өссөн байна. Орон сууцны үнийн индекс өмнөх улирлаас 1.4 хувиар өсөхөд 2001 оноос хойш

ашиглалтанд орсон шинэ орон сууцны үнэ Хан-Уул дүүрэгт 3.8 хувь, Баянгол дүүрэгт 2.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх улиралтай харьцуулснаар



## Ойлголт, тодорхойлолт

### Нийтийн орон сууц

Зориулалтын зураг, төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь дөрөв, түүнээс дээш сууцны зориулалттайгаар төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшинг ойлгоно.

### Жин

Нийт сууцны талбайн өртөгт тухайн бүлгийн орон сууцны талбайн өртгийн эзлэх хувь хэмжээ юм.

### Тооцох аргачлал

Орон сууцны үнийн индексийг тооцоход Ласпейрсийн хувиргасан индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

энд,

$I_{ct}^L$  – t үеийн с-бүлгийн (агрегат) Ласпейрсийн индекс

$P_{it}$  – i орон сууцны t тайлант үеийн үнэ

$P_{i0}$  – i орон сууцны 0 суурь үеийн үнэ

$Q_{i0}$  – 0 суурь үеийн i төрлийн сууцны өртгийн нийт орон сууцны өртөгт эзлэх хувь



### Эх үүсвэр

ҮСХ, Орон сууцны үнийн мэдээ

### Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 1 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн газрын  
Үнийн статистикийн албан гэрээт ажилтан  
Б.Оргил  
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212